



Байгаль орчны судалгаа, үнэлгээний
зөвлөх “ЭРТЭЧ НАРАН” ХХК

**ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМАНД
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА “ХАЯГДАЛ
ТҮҮХИЙ ЭД БОЛОН АВТЫН АЖИЛЛАСАН
ТОС АШИГЛАН ШАТАХУУН
ҮЙЛДВЭРЛЭХ” ТӨСӨЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2025 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Төсөл хэрэгжүүлэгч:

“ОБ ОЙЛ ИНДУСТРИАЛ” ХХК

ГАРЧИГ

1.	ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	1
1.1	Төслийн зорилго	1
1.2	Төслийн талбайн байршил.....	1
1.3	Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөө	2
1.3.1	БОМТ-ний баталгаажилт	2
1.4	Төслийн үйл ажиллагаа, технологи	3
1.4.1	Үйлдвэрийн технологи ажиллагаа	3
1.4.2	Үйлдвэрийн тоног төхөөрөмж.....	4
1.4.3	Үйлдвэрийн удирдлага зохион байгуулалт	5
2.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	5
2.1	Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	5
2.1.1	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	9
2.1.2	Хог хаягдлын менежмент	11
2.1.3	Удирдлага, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	14
3.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	18
3.1	Агаар орчны хяналт, шинжилгээ.....	18
3.1.1	Агаарын чанарын шинжилгээ	18
3.1.2	Агаар дахь тоосны агууламж.....	18
3.1.3	Агаар дахь хорт хийн агууламж	19
3.1.4	Хөрсний чанарын хяналт шинжилгээ.....	19
3.1.5	Усны шинжилгээнүүд.....	21
	Үйлдвэр нь технологийн усны багахан хэрэглээтэй. Тайланд хугацаанд усны 3 удаагийн шинжилгээ хийлгэсэн.....	21
3.1.6	Усны шинжилгээний үр дүн	21
4.	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	22
4.1	Компанийн удирдлага, менежмент.....	22
4.2	Хөдөлмөр зохион байгуулалт	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн байршлын болон үйл ажиллагааны тухай товч мэдээлэл.....	1
Хүснэгт 2. Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт	8
Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэх ажлын биелэлт.....	10
Хүснэгт 4. Ахуйн хог хаягдлын менежмент.....	11
Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал.....	12

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Байгаль орчны ес.mn мэдээллийн сан дахь 2025 оны БОМТ	3
Зураг 2. Хаягдал боловсруулах үйлдвэрийн худагт тавьсан усны тоолуур.....	6
Зураг 3. Об ойл индустриал ХХК-ий газар, хөрсийг хамгаалах үйл ажиллагаа	7
Зураг 4. Төслийн талбай, орчны газрыг хатуу хучилттай болгосон байдал	8
Зураг 5. 2025 онд 200 модыг мөчрөөр тарьж байгаа ажил, 2025-06-14.....	11
Зураг 6. Цооногийн болгож тохижуулсан энгийн жорлонгийн байдал, 2025-02-10	12
Зураг 7. Төслийн хашаан дахь хог хаягдлын нэгдсэн цэгийн тохижилт	14
Зураг 8. Хог хаягдал зайлуулах гэрээ, 2025-10-07	14
Зураг 9. Ажилчдын хамгаалах хэрэгслийн бэлдцүүд, 2025-09 сар.....	17

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн зорилго

Уг төсөл нь " ОБ ойл индастриал" ХХК-ийн хөрөнгө, дэд бүтцэд тулгуурлан Монгол улсын зах зээлд онцгой хэрэгцээтэй шингэн шатахууныг дотооддоо үйлдвэрлэн нийлүүлэх зорилготой бөгөөд зорилгод хүрэхийн тулд дараах зорилтот ажлуудыг 2024 онд хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:


- Монгол улсын хот суурин газруудаар ихээр хуримтлагдаж байгаа хаягдал түүхий эд хуванцар, ажилласан хаягдал тос цуглуулан авч шатахуун үйлдвэрлэж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн байгуулан улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулаад байна.
- Дэлхийн боловсруулах салбарт хэрэгжигдэж байгаа дэвшилтэт технологи ба арга барилуудыг эх нутагтаа нэвтрүүлэн мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэж байна.

1.2 Төслийн талбайн байршил

Төслийг хэрэгжүүлж буй талбай нь Төв аймгийн, Аргалант сумын 2-р багийн нутаг, Хөшөөт гэх газарт байршилтай бөгөөд төсөлд 2500мкв хэмжээгээр олгогдсон байна.

Хүснэгт 1. Төслийн байршилын болон үйл ажиллагааны тухай товч мэдээлэл

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төслийн нэр	“Хаягдал түүхий эд боловсруулан шатахуун үйлдвэрлэх”
2	БОНЕҮ-ийн дугаар	2023/ОА-78
3	Төсөл хэрэгжүүлэгч	“Об Ойл Индастриал” ХХК
4	Регистрийн дугаар	6987427
5	Үндсэн үйл ажиллагаа	38300 Хаягдал түүхий эд дахин боловсруулах
	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, БЗД, Энканто таун, 306-22
6	Төслийн хүчин чадал үйлчилгээний төрлүүд:	Тус үйлдвэр нь 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр, жилд 6 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулна. Хоногт үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ -Дизель түлш – 5 тн жилийн үйлдвэрлэлийн хугацаанд 1000 орчим тн шатахуун үйлдвэрлэнэ.
7	Хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт	ААН гэрчилгээ Газрын гэрчилгээ Кадастрын зураг Галын дүгнэлт Боломжит усны нөөцийн дүгнэлт Тохирлын гэрчилгээ
8	Холбоо барих	Утас: 9911-6845



Зураг 1. Төслийн талбайн хүрээлэн буй орчны байдал, Google Eart Pro

Төслийн талбайн бүс нутаг нь үйлдвэр-эдийн засгийн зориулалтаар газар олголт эрчимжиж байгаа бүс нутагт хамаарна.




Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал. Phanrtom-4

1.3 Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөө

1.3.1 БОМТ-ний баталгаажилт

БОЖАӨЯамны баталгаажилт. Төсөл хэрэгжүүлэгч 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль

орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, БОАЖСайдын 2019 оны 618 дугаар тушаалаар баталсан БОМТ-г боловсруулах, хянах, тайлагнах журмыг баримталсан ба хуульд заасан БОУАӨЯамны цахим санд байршуулсан бөгөөд Яамнаас тавьсан шаардлагын дагуу холбогдох материал бүрдүүлбэрийг хангаснаар 2025-07-25-ны өдөр баталгаажуулсан байна.




Зураг 1. Байгаль орчны еic.mn мэдээллийн сан дахь 2025 оны БОМТ

Өмнөх оны төлөвлөгөөний биелэлт. Төв аймгийн Аргалант сумын нутагт “Об ойл индустриал” ХХК-ий хэрэгжүүлж байгаа “Хаягдал түүхий эд боловсруулан шатахуун үйлдвэрлэх” төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийг аймгийн байгаль орчны газраас 7 мэргэжилтний хянан дүгнэснээр төлөвлөлтийн биелэлт нь 96-100 хувьтай буюу хангалттай гэж дүгнэсэн байдаг.

1.4 Төслийн үйл ажиллагаа, технологи


1.4.1 Үйлдвэрийн технологи ажиллагаа

Нийт түүхий эдийн нөөцийн 95% нь автомашинаас тухайлбал нийт нөөцийн 9% нь нь автотехникээс гардаг. 2% хүрэхгүй хэсэг нь төмөр зам гэх мэт бусад эх үүсвэрээс гардаг байна. Нөөц цуглуулах зайлшгүй чухал эх үүсвэр бол автомашин бөгөөд төсөл авто машины хаягдал тос гарах боломжтой бүх эх үүсвэрийг судалсны дотор шаардлага хангасан 63 авто засварын газруудыг хамруулсан байна.:



Зураг 1. Үйлдвэрийн боловсруулалтад хүлээн авдаг түүхий эдийн ангилал, бүтэц

Улаанбаатар хотод автомашин болон импортыг уялдуулан төсөөлөл боловсруулж үзэхэд батлагдсан буюу 13,166 тонн автын үнэмлэхүй их, бусад хэрэглээний зориулалттай тос орж ирдгээс боломжтой нөөцийг тогтоохдоо олон шалгуур үзүүлэлт тавьж бууруулах буюу гутранги хувилбарын дүн болох 10,004,150 литр гэж төсөл тооцсон.



Зураг 2. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ажлын дараалал ба технологийн схем

1.4.2 Үйлдвэрийн тоног төхөөрөмж

“Об ойл Индастри” ХХК-ний хэрэгжүүлэх “Хаягдал түүхий эд боловсруулан шатахуун гарган авах”-д дараах үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашигладаг. Үүнд:

- ДТБЗ-450-300 загварын ДТНЗ-960-200, /Дизель түлш боловсруулах зуух 450-300,
- Дизель түлш нэрэх зуух 960-200 /
- Хаягдал каучук, дахин ашиглаж карбон ба ажилсан масло тосыг зэргийг боловсруулдаг нэг ком тоног төхөөрөмж нь 7 хэсгээс бүрдэнэ:
- Хэвтээ хэлбэрийн эргэлдэгч, задлагч машин
- Материал оруулах систем
- Даралт, температурыг мэдээлэх систем
- Төвийн цахилгаан удирдах систем
- Ёмкость хэлбэрийн хөргөгч систем
- Шатах хийг халаах систем/ хаягдал хийг боловсруулах • Утаа, тоос хүхэр ялгах, цэвэрлэх систем



Зураг 3. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж, тэдгээрийн угсралтын байдал

1.4.3 Үйлдвэрийн удирдлага зохион байгуулалт

Үйлдвэр нь технологи, борлуулалт, санхүүгийн нэгдсэн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах функциональ удирдлагын тогтолцоотой.



Зураг 4. Үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалтын нэгжийн бүтэц

Үйлдвэрт нийт 15 хүн байнгын ажлын байраар хангагдаж ажилладаг бөгөөд тэдгээрийн ажил үүргийн хуваарийг удирдлагын зүгээс баталсан байдаг.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. Агаар, орчныг чанарыг хамгаалах, үзүүлж буй сөрөг нөлөөг хянах, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх зүйн дараах баримт бичгүүд, стандартуудыг мөрдлөг болгон ажилласан. Үүнд:

- “Агаарын тухай” хууль, 2012 он
- “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль, 2010 он;
- MNS 4585:2007. “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”;
- MNS (ISO) 4226:2000 “Агаарын чанар”;
- MNS 4585:2008

Агаарт үзүүлсэн сөрөг нөлөөг бууруулах ажлын хүрээнд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, галын аюулгүй байдлыг хангах зэрэг бусад төлөвлөлтийн ажлуудыг хэрэгжүүлсэн болно.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. Усны орчныг хамгаалах, усны орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг хянах, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх зүйн дараах баримт бичгүүд, стандартуудыг мөрдлөг болгон ажилласан. Үүнд:

- “Усны тухай” хууль, 2012 он;
- “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хууль, 2012 он
- MNS 0900:2010. “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах.
- Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”

Усыг ариг гамтай, алдагдал багатайгаар ашиглах, усны эх үүсвэрийг тоолууртай болгох ажлыг хийж гүйцэтгэсэн болно.



Зураг 2. Хаягдал боловсруулах үйлдвэрийн худагт тавьсан усны тоолуур

Хөрс, ургамал, амьтдыг хамгаалах. Хөрс, ургамал, амьтдыг хамгаалах, эдгээрт үзүүлж буй сөрөг нөлөөг хянах, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх зүйн дараах баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажилласан. Үүнд:

- Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012.05.17
- Ургамал хамгааллын тухай хууль, 2007.11.15
- Амьтны тухай хууль, 2012.05.1
- Хог хаягдлын тухай хууль, 2017.05.12

“ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ”ХХК

Батлав
“ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ”ХХК
Гүйцэтгэх Захирал Т.Одсүрэн
ХХК

Цэвэрлэгээний талбай

Ээлж	Гадна талбай	Хугацаа	Тоноглол	Хугацаа
1-р Ээлж	Бак-нуудын хэсэг	Сар бүрийн 5,10 Өдрүүдэд	1-р Зуухнаас хойших тоноглол	Гараа болгонд
2-р Ээлж	Бак-нуудын хэсэг	Сар бүрийн 15,25 Өдрүүдэд	1-р Зуухнаас хойших тоноглол	Гараа болгонд
3-р Ээлж	Зүүн,Урд	Сар бүрийн 5,10 Өдрүүдэд	2-р Зуухнаас урагшаа тоноглол	Гараа болгонд
4-р Ээлж	Баруун,Урд	Сар бүрийн 15,25 Өдрүүдэд	2-р Зуухнаас урагшаа тоноглол	Гараа болгонд

Гадна талбайд хийгдэх зүйлс

- Орчины хог цэвэрлэх
- Тос масло асгарсан үед цэвэрлэх
- Унаж гэмтсэн зүйлсийг сэлбэж засварлах
- Удирдах албан тушаалтаны зааварчилгааг дагаж эмхлэх, цэгцлэх

Тоноглолын цэвэрлэгээ хийх

- Орчины хог цэвэрлэх
- Бак,сав филтерт гадна цэвэрлэгээ хийх /Тоос шороог цэвэрлэх/
- Усан цэвэрлэгээ
- Тоноглолын нэр пайз унаж гэмтсэн болсон засаж сэлбэх
- Удирдах албан тушаалтаны зааварчилгааг дагаж эмхлэх цэгцлэх

Хянасан: Гүйцэтгэх Захирал /
Боловсруулсан:ХАБИнженер /

Зураг 3. Об ойл индустриал ХХК-ий газар, хөрсийг хамгаалах үйл ажиллагааны зохицуулалт



Зураг 4. Төслийн талбай, орчны газрыг хатуу хучилттай болгосон байдал

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилт. 2024 онд 600 м² талбайд улиас голлосон ногоон зурвас тохижуулж, зүлэгжүүлэлтэд ерхөг, царгас тарьж өгсөн болно. Тохижуулсан ногоон бүсэд ургамлан нөмрөг 35-50 хувийн бүрхэцтэй болж, тарьсан модны амьдрах чадавх 60.0 гаруй хувьтай байна.


Хүснэгт 2. Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	Биелэлтийн тайлбар
АГААР			
1.	Тоосжилт, утаа, зохисгүй үнэр үүсэж тархан орчны агаарын чанарт нөлөөлөх.	Тоосжилт үүсэх ямар нэг эх үүсвэр гаргахгүй, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, төлөвлөөгүй эвдрэл үүсгэхгүй гм	Үйлдвэрийн барилга байгууламжийн орчинд газрын сайжруулах, тохижуулах ажлуудыг дэс дараатай хийж эхлээд байгаа.
2.	Хавар, намрын хуурайшилттай улиралд гал алдах нөхцөл үүсэх	Татсан тамхи, ил асаасан галыг заавал унтрааж байх, зориулалтын газар, зориулалтын битүү саванд хаяж байх талаар санамж, анхааруулгыг ил байршуулах	Төслийн талбайд тамхи татах, гал гаргах асуудал үүсгэхгүйгээр хөдөлмөр хамгааллын нөхцөлийг бүрдүүлж, дүрэм журам боловсруулан хэрэгжүүлж хэвшсэн.
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС			
1.	Ил задгай хаясан хог хаягдлаас орчны газар бохирдож үер ус аар зөөвөрлөгдөх	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг хэрэгцээт газруудад байршуулах ажлыг үргэлжлүүлэх	Төсөл өөр дээрээ үүссэн хог хаягдлыг өөр дээрээ түр хугацаагаар хадгалж байгаад сумын ЗД-тай хийсэн гэрээний дагуу зайлуулдаг.
2.	Унд ахуйн болон бусад хэрэгцээний усыг их хэмжээгээр замбараагүй хэрэглээ	- Усыг ариг гамтай, алдагдал багатайгаар ашиглах - Анхааруулга, санамж байршуулах - Тоолууржуулах	206292 тоот гэрчилгээтэй тоолуурыг 2025-01-22-нд тавиулсан ба тоолуурын заалт 00001 м ³ -ээс эхэлсэн байгаа.
ХӨРСӨН БҮРХЭВЧ			
1.	Олон салаа зам гаргаснаас хөрс элэгдэж эвдрэх	Зураг төсөлд тусгаагүй газарт нүх ухах, барилга байгууламж барихыг хориглох	Төслийн талбайн орчинд олон салаа зам үүсэх нөхцөл байдал нь манай компаниас хамааралгүй бөгөөд харин олон салаа замын нөлөөллийн бүсэд төслийн талбай байршиж

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	Биелэлтийн тайлбар
			байгаа болно. Харин манай үйл ажиллагаанд байнга ашиглагдаж байгаа замын тухайд тухайлсан тэмдэг, тэмдэглэгээ,
2.	Орчны талхагдал, доройтол	Ногоон байгууламж, мод сөөг тарих, арчлах .	Өнгөрсөн жил 330.0 мод тарьсан нь ба энэ жил 200 модны тарьц шинээр тарьж ургуулж байна.
ГАЗРЫН ХЭВЛИЙ			
1.	Орчны олон салаа замын нөлөөгөөр гуу жалга үүснэ.	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж хяналт мониторинг хийнэ.	Тийм нөхцөл байдал илрээгүй.
УРГАМЛАН НӨМРӨГ			
1.	Хашааны дотор болон гадна талд газар тахлагдсан газар тэлэх	Хүн техникийн хөлөөс зайдуу, булан бүхий газарт мод бут тарих, ногоон бүс болгох	Эзэмшил газрын хүрээнд ногоон байгууламж боломж нөхцөл хязгаарлагдмал тул хашааны гадна талд хуучин хогийн цэгийг булшилсан газарт мод тарьж байгаа.
2		Төслийн үйлдвэр рүү ирэх замыг нэг голдиролд оруулан тэмдэгжүүлэх, гадна талын олон салаа замыг хумих	Хашааны гадна 1000 хүртэл м-т замд тухайлсан нэг маршрут сонгож тээвэрлэлт хийж байгаа.
АМЬТНЫ АЙМАГ			
1.	Ил задгай хаясан хог хаягдал болон бохирдсон өвс, ургамлыг мал амьтан идэж хордох	- Хог хаягдлыг ангилан ялгах, дор бүр нь зайлуулах, - Түргэн муудах, ялзрах хог хаягдлыг удаан хадгалахгүй байх:	Төслийн талбай түр хадгалж байгаад эрх бүхий байгууллагад шилжүүлж байгаа ба төслийн талбайг битүүд нь хатуу хучилттай болсноор хог хаягдлаар хөрс бохирдох замыг хаасан.

2.1.1 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Ногоон байгууламж хийх газрын байршил. Монгол улсын ерөнхийлөгчийн санаачлагчаар хэрэгжиж буй “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оноос 2025 он хүртэл нийтдээ 200 орчим шилмүүст моддыг тарих бөгөөд 2023 оны 4-р сард эхний 100ш модыг тарихаар төлөвлөсөн бөгөөд 2024 болон 2025 онуудад тус тус 50ш модыг тарихаар төлөвлөсөн тухай төслийн БОННУ-нд дурдсан бий. Энэ нь үйлдвэрийн хашаан дотор зохион байгуулах ногоон байгууламж салшгүй холбоотой ба 2025 онд үйлдвэрийн хашааны доторх баруун хэсэгт 48 м урттай, 2 м өргөнтэй зурвасыг ургамалжуулахаар төлөвлөснөөр хийж байгаа болно.



Зураг 5. Үйлдвэрийн хашаан дотор болон гадаах ногоон байгууламж зохион байгуулах байришил


Ногоон бүс тохижуулах гадаах хэсэг үйлдвэрийн талбайн зүүн талд 2024 онд булшилж цэвэрлээд 300 мод тарьж ургуулсан газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ. 2025 онд тус газарт 200 ш навчит мод нэмж суулгахаар төлөвлөснийг бүрэн тарьсан болно. Тарьсан мод ургуулах, амьдрах чадвартай болгох нь он жилүүдээр хийгдэх ажил бөгөөд өнгөрсөн 2024онд тарьсан модны амьдрах чадвар 60.0 хувь байсныг энд тэмдэглэж байна.

Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэх ажлын биелэлт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Биелэлт
1.	Төслийн объектын орчныг тохижуулах.	- Хашаан доторх зурвас газрыг ургамалжуулна. - Ургамалжуулсан талбайг усалж, арчилна.	
2.	Хашааны гаднах цэцэрлэгт хүрээлэн хийх ажлыг үргэлжлүүлнэ.	- Хашиж хамгаалсан талбайг ургамалжуулна. - Мод нэмж тарина, нийт 500 ш мод ургуулсан байна.	2025 онд 330 мод тарьсан амьдрах чадвар нь 60 хувь байсан.
			2025 онд 200 мод тарьсан
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн нийт зардал8,630.4 мянган т			

Тарих ургамлын нэр төрлийн сонголт. Бэлтгэсэн хөрсний орчинд тохируулан бүс нутагт ургах боломжтой таримал ургамлыг сонгоно. “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-д заасан үр дүнгийн хугацааг богиносгох зарчмыг баримталж, “MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага” стандартыг мөрдөж нөхөн сэргээлтийн орчинд хурдан

ургаж биомасс бүрдүүлэх чадвартай гэж улиасыг сонгон тарьж байгаа бөгөөд сонгосон талбайд тарьсан модны амьдрах чадвар 80-920 хувьтай болоход зүлэгжүүлэх ажлыг хийхээр хүлээж байгаа болно.



Зураг 5. 2025 онд 200 модыг мөчрөөр тарьж байгаа ажил, 2025-06-14

2.1.2 Хог хаягдлын менежмент

Ахуйн хог хаягдал. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хуульд заасан хүрээнд хэрэгжүүлэх боломжит зохион байгуулалтаар хангахаар төлөвлөгөөнд тусгаснаас дараах байдлаар гүйцэтгэл нь хангагдсан болно.

Хүснэгт 4. Ахуйн хог хаягдлын менежмент

№	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Ажилчдын байрны ахуйн хог хаягдлыг ангилсан байдлаар цуглуулах савнуудаар	Төслийн талбайд ахуйн хаягдлыг түр хадгалах нэгдсэн хогийн цэгийг байршуулсан ба ачилтын хэмжээнд хүртэл хадгална.

№	Төлөвлөлт	Гүйцэтгэл
	хангах хогийн нэгдсэн цэг байгуулан түр хадгалах нөхцөлөөр хангана.	
2	Ажилчдын хэрэглээний үл шүүрүүлэх цооногтой нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, үр дүнг нь хяналт мониторингоор хянана.	Энгийн нүхэн жорлонг цооногийн хуримтлалтай болгож агааржуулалтын яндан, сэнсээр тоноглосон.
3	Ажилчдын хотхонд бие даасан үйлчилгээтэй, дундаж хүчин чадалтай цэвэрлэх байгууламж байршуулан, септик технологиор цэвэршүүлэн цэвэршүүлсэн бохир усыг ууршуулан зайлуулна.	Төслийн талбайд цэвэршүүлэх байгууламж тавих шаардлагагүй бөгөөд цооногийн технологиор ашиглаж байгаа нь төсөлд тохиромжтой.
4	Үйлдвэрлэлийн болон барилгын засварын будаг, цавуу зэрэг бодисын сав баглаа боодлыг аюултай хог хаягдал хүлээн авах, боловсруулах эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гэрээнд заасан графикайн дагуу зайлуулна.	Цооногийн нүхэн жорлонгийн нөөцийн хэмжээ одоогоор соруулан зайлах хэмжээнд хүрээгүй байгаа тул цооногоос бохирдол гадагшилж орчны бохирдуулах нөхцөлгүй байна. Тиймээс ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүсээгүй болно.

Хог хаягдлыг зайлуулах хүртэл түр хадгалах нөхцөлийг сайжруулахад тохирох шаардлагыг хангаж дотоод хяналт тавьж ажиллана. Үүнд:

- Үүссэн хог хаягдлыг тээвэрлэн зайлуулах хүртэл эх үүсвэр дээр нь цуглуулж аль болох богино хугацаагаар хадгална.
- Хог хаягдлын цэг нь үүссэн хаягдлыг ангилсан байдлаар түр хадгална.
- Түр хугацаагаар хог хаягдал хадгалах төвлөрсөн цэг нь элдэв үнэр гаргахгүй, хог хаягдлыг норгохгүй, хийсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Хуримтлуулж, цуглуулсан хог хаягдлыг ангилал бүрээр эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.



Зураг 6. Цооногийн болгож тохижуулсан энгийн жорлонгийн байдал, 2025-02-10

Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
----------------------	---	-----------

-Ахуйн хатуу хог хаягдал, тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс агаар, хөрс, усыг бохирдуулах, сөрөг нөлөөлөл учруулах.	Тайлангийн 5.1-д тооцсоны дагуу жилд 1.0 тн хог хаягдал гарна. -Хатуу хог хаягдлыг ангиалан ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг байршуулах, -Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг эрх бүхий байгууллагад хүргэж өгөх; Ахуйн шингэн бохирыг зайлуулах төлбөр төлөх гэрээтэй байх	- Аргалант сумын ЗД-тай байгуулсан гэрээг 2025-10-05-нд шинэчилж байгуулсан. - Төслийн хогийн нэгдсэн цэгийг зохион байгуулж ангилсан байдлаар түр хадгална. - Цооногийн ашиглалтаас шалтгаалан шингэн бохир зайлуулах шаардлага үүсээгүй байна.
--	---	--

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, түүнээс үзүүлж буй сөрөг нөлөөг хянах, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх зүйн дараах баримт бичгүүд, стандартуудыг мөрдлөгө болгон ажилласан. Үүнд:

- “Хог хаягдлын тухай” хууль, 2017 он; шинэчилсэн найруулга
- MNS 5924:2008. Галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага
- “Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах”;
- MNS 5850:2008, “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”, ISO15799:2003
- MNS 0900:2010 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”
- MNS4943:2011“Ундны болон үйлдвэрлэлийн хэрэгцээт усны химийн шинжилгээ болон дээж авах, хадгалах”; MNS(ISO)5667-5:2001 “Усны чанар- дээжлэлт”.

Үйлдвэр 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр жилийн турш үйл ажиллагаа явуулах ба одоогийн байдлаар бүрэн орон тоогоор ажиллаагүй тул хог хаягдлын гарц бага байна.

Table 1. Үйлдвэрийн хог хаягдлын хэмжээ, 2024 онд

Д/д	Хэмжих нэгж /гаралты н хэмжээ	Хугацаа /хоногоор/	Хог хаягдал гаргах эх үүсвэрийн тоо	Нийт хэмжээ кг
1.	кг/0.6	Өдөрт /1/	4	2.4
2.	кг/0.6	Сард /30/	4	72.0
3.	кг/0.6	Үйл ажиллагааны 4 сард	4	193.5

Үйлдвэрийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь цуглуулах нийт 2 цэг байгаа тэдгээрт цугласан хогийг үйлдвэрийн хогийн нэгдсэн цэгт хүргэж ангиалан хадгалж байгаад гэрээний үндсэн зайлуулах менежментийг хэрэгжүүлэн хэвшил болгож байна..



Зураг 7. Төслийн хашаан дахь хог хаягдлын нэгдсэн цэгийн тохижилт

Үйлдвэр нь 2025 оны байдлаар өөр дээрээ үүсгэсэн хог хаягдлыг 3 удаа зайлуулсан бөгөөд бөгөөд энэ нь цугларсан хог хаягдал ачилт хийх хэмжээнд хүрэх нөхцөлтэй холбоотой юм.



Зураг 8. Хог хаягдал зайлуулах гэрээ, 2025-10-07

2.1.3 Удирдлага, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

2024 оны удирдлага менежментийг ХАБ-ын бодлогыг боловсруулахад чиглүүлсэн. Үүнтэй холбоотойгоор үйлдвэрийн дотоод журам, ХАБ-ын харилцааг зохицуулсан дараах баримт бичгүүдийг боловсруулаад байна. Үүнд:

- Хөдөлмөрийн дотоод журам

- Цахилгаан, цахилгаан тоноглолын аюулгүй ажиллагаа
- Цахилгаан болон гар багажийн аюулгүй ажиллагаа
- Үйлдвэрийн тоноглолын аюулгүй ажиллагааны дүрэм зэрэг болно.

Эдгээрээс гадна ээлжийн тэмдэглэл, саруудын график зэрэг өдөр тутмын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хянах чек листүүдийг бэлтгэсэн болно.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ

Г.ОДСҮРЭН

2024оны дугаар сарын өдөр

“ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ”ХХК

ЭЭЛЖИЙН АЖИЛЧДЫН ГРАФИК

I	II	III	IV	10-САР				
21	A	9	0		3	11	19	27
0	21	9	A		4	12	20	28
A	0	21	9		5	13	21	29
21	A	0	9		6	14	22	30
0	9	A	21		7	15	23	
A	9	21	0		8	16	24	
9	21	0	A	1	9	17	25	
9	0	A	21	2	10	18	26	

9

-Өглөө 09:00 ажиллана.

21

-Орой 21:00 ажиллана

ХЯНАСАН:
ҮЙЛДВЭРИЙН ДАРГА

М.ЖАРГАЛСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН
ХАБ-ИНЖЕНЕР

О.ОДБАЯР



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ

Г.ОДСҮРЭН

2024оны дугаар сарын өдөр

“ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ”ХХК

ОПЕРАТОР / /

ЗУУХ №1				ЗУУХ №2			
ЦАГ	ЗУУХ	БҮРХЭЭР	КАТАЛИЗАТОР	ЦАГ	ЗУУХ	БҮРХЭЭР	КАТАЛИЗАТОР
10:00				22:00			
11:00				23:00			
12:00				24:00			
13:00				01:00			
14:00				02:00			
15:00				03:00			
16:00				04:00			
17:00				05:00			
18:00				06:00			
19:00				07:00			
20:00				08:00			
21:00				09:00			

ЭЭЛЖИЙН ТЭМДЭГЛЭЛ

Зураг 3. Үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагааны чек листүүдийн загварууд



Зураг 4. Үйлдвэрийн эрчим хүчний холболт ба аюулгүй байдлын самбарын хийцүүд, 2025-06 сар



Зураг 9. Ажилчдын хамгаалах хэрэгслийн бэлдцүүд, 2025-09 сар

3. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1 Агаар орчны хяналт, шинжилгээ

3.1.1 Агаарын чанарын шинжилгээ

Агаарын чанарын шинжилгээг 2024 онд 1 удаа хийлгэж, үйлдвэрийн орчны агаарт тархалттай 8-11 нэр төрлийн бохирдуулах бодисын тархалтыг тодорхойлсон болно.

Хүснэгт 2. Агаарын чанарын шинжилгээгэр илэрсэн агаар бохирдуулах бодисууд

Үйлдвэрийн доторхи орчны үзүүлэлтүүд	Гадаар орчны үзүүлэлтүүд
1. Озон 2. Аммиак 3. Формальдегид 4. Бензол 5. Толуол 6. Этилбензол 7. м,п ксилол 8. о ксилол 9. хүхэрт ус төрөгч 10. нүүрстөрөгийн дутуу исэл 11. нүүрсхүчлийн хий	1. Озон 2. Аммиак 3. Формальдегид 4. Бензол 5. Толуол 6. Этилбензол 7. м,п ксилол 8. о ксилол

3.1.2 Агаар дахь тоосны агууламж

Үйлдвэрийн орчинд буюу төслийн эзэмшлийн талбайд тоосны агууламж үйлдвэрлэл явагдаж байх мөчлөгт MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.5-2.3 дахин их байна. Үйлдвэрийн бүс дотор агаар дахь нарийн ширэглэгтэй PM2.5 тоосны тархалт стандартаас 1.5 дахин, том ширхэглэгт PM 10 тоосны тархалт 2.3 дахин их байна.



Зураг 5. Үйлдвэрийн хашаанд хийсэн тоосны хэмжилтийн үр дүн¹

¹ Эрүүл ахуй, хор судлалын лаборатори, 2023-02-026 REP 1202035.

3.1.3 Агаар дахь хорт хийн агууламж

Төслийн үйлдвэрийн орчин, үйлдвэрийн хашаан доторх хийсэн агаарын чанарын хэмжилтээр үйлдвэрийн орчин дахь агаарт хүнд металлын агууламж MNS6342:2012 хүний эрүүл мэндэд нөлөөлөх хүлцэх дээд хэмжээнээс олон дахин бага байна.

Хүснэгт 3. Үйлдвэрийн орчинд хийсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүн

№	Агаар бохирдуулагчид	Хэмжих нэгж	ХДХ	Шинжилгээний хугацаа	
				2025-04-13	2025-09-17
1	Озон, O ₃	мкг/куб м.	100	0.96	0.05
	Аммиак	мкг/куб м.	200	0	269.93
	Формальдегид	мкг/куб м.	0.05	<0.5	1.9
2	Бензол, C ₆ H ₆	мкг/куб м.	10	<0.5	<0.5
	Толуол, PhMe	мкг/куб м.		<0.7	<0.7
	Этилбензол, C ₈ H ₁₀	мкг/куб м.		<0.5	<0.5
3	м,п ксилол, (CH ₃) ₂ C ₆ H ₄	мкг/куб м.	10	<0.8	<0.8
4	о ксилол	мкг/куб м.		<0.8	<0.8
5	хүхэрт ус төрөгч, H ₂ S	мкг/куб м.	0.35	0	0
6	Нүүрс төрөгийн дутуу исэл	ppm	50	<1	<1
7	нүүрсхүчлийн хий буюу хүлэмжийн хий	мкг/куб м.	-	948016.57	1918279.25

3.1.4 Хөрсний чанарын хяналт шинжилгээ

2024 оны үйл ажиллагаагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаагүй тул хөрсний чанарт бохирдлын өөрчлөлт ороогүй болно.

Хүснэгт 4. Төслийн талбайн хөрсний агрохимийн үзүүлэлт

Дээжийн дугаар	Гүн,см	рНН2О (1:2.5)	CaCO ₃ %	Ялзмаг %	EC2.5, Ds/m	Хөдөлгөөнт Мг/100г	
						P ₂ O ₅	K ₂ O
Хөрс	0-20	7.61	0.0	11.71	0.036	1.5	3

Table 5. Төслийн талбайн хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжийн дугаар	Гүн,см	Ширхгийн хэмжээ,%(мм-ээр)		
		Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)
Хөрс	0-20	42.8	31.3	24.9

Хяналт шинжилгээний дээжийг магадлан итгэмжлэгдсэн ХАНЛАБ лабораторид шинжлүүлсэн бөгөөд шинжилгээний дүнг MNS 5859:2019 стандарттай харьцуулахад үйлдвэрийн орчинд хүнд металлын агууламж илрээгүй болно.

Хүснэгт 6. Төслийн талбайн хөрсний хүнд металлын бохирдлын үзүүлэлт

Химийн элемент	Элементийн нэр	хэмжих нэгж	Хүлцэх хэмжээ	MNS 5859:2019	Л-16083
As	Хүнцэл	ppm	2	20.00	8.08
Ba	Бари	ppm	10		735.2
Be	Берилли	ppm	0.5		2.56
Bi	Висмут	ppm	2		<10.0
Ca	Кальци	%	0.01		1.56
Cd	Кадми	ppm	0.5	3.00	<1.0
Co	Кобальт	ppm	1	50	20
Cr	Хром	ppm	1	150	84.34
Cu	Зэс	ppm	1	100	23.79
Fe	Төмөр	%	0.01		3.42
K	Кали	%	0.01		2.15
La	Лантан	ppm	10		43.92
Li					36.48
Mg	Магни	%	0.01		0.9
Mn	Манган	ppm	5		841.4
Mo	Молибден	ppm	1	5	<5.0
Na	Натри	%	0.01		2.38
Ni	Никель	ppm	1	150	27.14
P	Фосфор	ppm	10		648.9
Pb	Хар тугалга	ppm	2	100	29.12
Sb	Сурьма	ppm	2		<10.0
Sc	Сканди	ppm	1	10	6.88
Sr	Стронци	ppm	1		289.5
Th	Тори	ppm	20		800
Ti	Титан	%	0.01		4327
V	Ванади	ppm	1	150	106.5
Zn	Цайр	ppm	2	300	80.31
Zr					110.7
Y					30.82

Хөрсний дээжид хийгдсэн хүнд металлын лабораторийн шинжилгээний үр дүнгээс As, Cd, Co, Cr, Cu, Mo, Ni, Pb, Se, Sr, V, Zn зэрэг хүн амьтан ургамлын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө үзүүлдэг 12 элементийн агууламжийг сонгон “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандартын хүлцэх дээд агууламжтай (S-1 шавранцар) харьцуулж үзсэн. Хүнд металл тодорхойлсон лабораторийн шинжилгээний дүнгээс харахад судалгаанд хамрагдсан бүх дээжүүдэд Cd, Mo, зэрэг элементүүд багажийн мэдрэх хязгаарт багтаагүй буюу маш бага агууламжтай байсан. Мөн As, Co, Cr, Cu, Ni, Pb, Se, Sr, V, Zn зэрэг элементийн агууламж MNS 5850:2019 стандартын шавранцар хөрсний хүлцэх дээд агууламжаас хэтрээгүй.

3.1.5 Усны шинжилгээнүүд


Үйлдвэр нь технологийн усны багахан хэрэглээтэй. Тайланд хугацаанд усны 3 удаагийн шинжилгээ хийлгэсэн.

Хүснэгт 7. Тайланд хугацаанд усны шинжилгээнүүд

№	Шинжилгээний объект	Захиалга	Шинжилгээ код	Лаборатори	
1	Гүний худаг	2024/1582-5	GW-18 цэвэр	ХАНЛАБ	Чанарын шинжилгээ
2	Ус 1	2024/1582-1	Л-16075	ХАНЛАБ	Чанарын шинжилгээ
3	Ус 1	2024/1582-5	Л-16075	ХАНЛАБ	Хүнд металлын шинжилгээ

3.1.6 Усны шинжилгээний үр дүн

“Об ойл индастриал” ХХК-ийн төслийн талбайн усны чанар, найрлагад үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдөр гүний худгийн 1 сорьцыг Байгаль орчин. Усны чанар. Дээж авах MNS ISO 5667:2001 стандартад заагдсан арга аргачлалын дагуу цуглуулсан.



Зураг 6. Усны шинжилгээ авсан худгийн байршил

Эрдэсжилт. Судалгааны талбайн уст цэгийн эрдэсжилтийн агууламжийг MNS 0900:2018-тай харьцуулан зураг-4-т харуулав. Уст цэгүүдийн ус нь эрдэсжилтийн агууламжаар цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй (437.98 мг/л) ангилалд хамаарна.

Хатуулаг. Газар доорх усны сорьцыг хатуулгаар ангилахад худгийн усны сорьц нь хатуу (8.59 мг-экв/л) ангилалд хамаарагдах ба MNS 0900:2018 стандартаас 1.2 дахин хэтэрсэн байна. хатуулаг дотроо магнийн ион давамгайлж байна.

Хүнд металл. Өөрийн эзэмшлийн худгаас авсан усны шинжилгээнээс үзвэл гүний худгийн усанд хүнд металлын агууламж холбогдох стандартын хүлэх хэмжээнээс хэтэрч илрээгүй.

4. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Компанийн удирдлага, менежмент

Компани үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэхэд 2023 оноос эхлэн орон нутгийн удирдлагатай хамтарч ажилласан. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн эхний ажил нь Хөшөөт багийн Баянцогт уул орчимд ухсан ихэнхэд хуримтлагдсан хур хог, малын сэг зэмийг устгаж цэвэрлэн нөхөн сэргээлт хийж орчинд нь мод тарьсан. Тус ажлыг зохион байгуулахад 25.0 орчим сая төгрөгийн зардал компани өөрийн хөрөнгөөсөө гаргасан.

Хүснэгт 8. Баянцогт уул орчимд хийсэн ажлын зардлын товчоо

№	Зориулалт	Өдрийн тоо	Нэгжийн үнэ / өдрөөр	Нийт
1	Экскаватор түрээс /операторын хамт/	4	1,100,000.00	4,400,000.00
2	Ковш /операторын хамт/	4	1,300,000.00	5,200,000.00
3	Ачааны машин – 2ш /жолоочийн хамт/	4	1,350,000.00	5,400,000.00
4	Түлш шатахуун, масло /ирж, явах чиглэлийн хамт/	5	2,000,000.00	10,000,000.00
Нийт зардал				25,000,000.00

Үүний зэрэгцээ харьяа багийн иргэдээс орон нутгийн худалдан авалтаар сүү болон тараг, цагаан худалдан авч ажилчдадаа хоолны нэмэгдлээр өгдөг нь эрүүл мэндэд сайнаар нөлөөлж байна. Үүнд:

- Малчин Цэгмид болон Анхбаяраас сүү,
- Малчин Мягмарсүрэнгээс тараг, цагаан идээ худалдан авдаг бөгөөд үйлдвэрийн хэвийн ажиллагаатай үед өдөр бүр 10-15 л сүү тараг, 1.5-2.0 кг цагаан худалдан авч заншсан.

Эдгээрээс гадна орон нутгийн цаг үеийн ажилд оролцооны болон эдийн засгийн тусламж үзүүлж хамтран ажиллаж ирснээр “Малчдадаа тусалъя” сайн үйлсийн аянд оролцсон талархлын хуудсаар баримтжуулсан нь бий.

Зураг 9. Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт үзүүлсэн хандив тусламжийн мэдээлэл

Огноо	Хийсэн ажил нэр	Хаана	Үнийн дүн Төгрөг
2023 – 07 – 01	Хөшөөт багийн конторын тохижилтонд зориулж хандивлав.	Аргалант сумын Хөшөөт баг	1,000,000.00₮
2023 – 12 – 20	Шинэ жилийн арга хэмжээний хүрээнд сумын иргэдэд гарын бэлэг хандивлав.	Аргалант сум	1,350,000.00₮
2024 – 01 – 30	Зудын гамшигийг даван туулахад зориулж 200л дизелийн түлш хандивлав.	Аргалант сум	600,000.00₮
2024 – 02 – 01	Аргалант сумын уурын зууханд коксжсон нүүрс 2тонныг хандивлав.	Аргалант сум	1,440,000.00₮
2024 – 11 – 05	Монгол бахархлын өдрийг тохиолдуулан хандив.	Аргалант сум	1,000,000.00₮
Нийт дүн			5,390,000.00₮



4.2 Хөдөлмөр зохион байгуулалт

ЭЭЛЖИЙН АЖИЛЧДЫН ГРАФИК

I	II	III	IV	10-САР				
21	A	9	0		3	11	19	27
0	21	9	A		4	12	20	28
A	0	21	9		5	13	21	29
21	A	0	9		6	14	22	30
0	9	A	21		7	15	23	
A	9	21	0		8	16	24	
9	21	0	A	1	9	17	25	
9	0	A	21	2	10	18	26	



ОБ ОЙЛ
ИНДАСТРИАЛ ХХК

БАТЛАВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
2025оны дугаар сарын өдөр

Г.ОДСҮРЭН


“ОБ ОЙЛ ИНДАСТРИАЛ”ХХК ЭЭЛЖИЙН АЖИЛЧДЫН ГРАФИК

I	II	III	IV	3-САР				
20	A	8	0		4	12	20	28
0	20	8	A		5	13	21	29
A	0	20	8		6	14	22	30
20	A	0	8		7	15	23	
0	8	A	20		8	16	24	
A	8	20	0	1	9	17	25	
8	20	0	A	2	10	18	26	
8	0	A	20	3	11	19	27	

8 -Өглөө 08:00 ажиллана.

20 -Орой 20:00 ажиллана

ГАЛААС АВРАХ ТӨЛӨВЛӨГӨӨ



АШИГЛАСАН МАТЕРИАЛ



“ЭРТЭЧ НАРАН” ХХК

Утас: 9914-2530, 9638-0199

Майл хаяг: ertechnaran@gmail.com

